



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,
Утас: 26 04 37, Факс: (976) 6226 3230,
E-mail: info@audit.gov.mn, http://www.audit.mn

2017.02.23. № 3/321.
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.1, Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасны дагуу 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон холбогдох бусад тайлбар тодруулга бүхий санхүүгийн тайланд аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаархи мэдээлэл

Иргэний нисэхийн ерөнхий газрын харъяа газрын тусгай үйлчилгээний албаны удирдлага нь Төсвийн тухай хуулийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангууд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Нягтлан бодогчдын олон улсын холбооноос баталсан Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлж Монгол Улсын Үндэсний аудитын газраас гаргасан Санхүүгийн аудитын гарын авлагын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, гарын авлагын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.

Аудитаар санхүүгийн тайлан дахь дүн хэмжээ болон илчлэл тодруулгыг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгадаг. Түүнчлэн аудитаар удирдлагын ашигласан нягтлан бодох бүртгэлийн зарчим, хийсэн чухал тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлдэг.

Бидний хийсэн аудит санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

Зөрчилгүй санал дүгнэлт

Иргэний нисэхийн ерөнхий газрын харъяа газрын тусгай үйлчилгээний албаны 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, бодитой илэрхийлсэн байна.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

B. M

Ц.НАРАНЧИМЭГ

\\10.10.10.20\Bichig_Kherreg\Yawsan_Bichig\2017\0223SAG27.Docx

УХА0122

07.03.17



YAG
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

ИНЕГ-ЫН ХАРЪЯА ГАЗРЫН ТУСГАЙ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЛБАНЫ 2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

АУДИТЫН ТАЙЛАН

**Нэмэлт мэдээлэл авахыг
хүсвэл дараах хаягаар
харилцана уу:**

Санхүүгийн аудитын
газрын дарга С.Энхзаяа
Утас: 261663
enkhzayas@audit.gov.mn

Аудитын менежер Я.Самбууням
Утас: 260512
sambuunyamya@audit.gov.mn

Аудитор Н.Нямдаваа
Утас: 260512
nyamdavaan@audit.gov.mn

“Ньюбаланс аудит” ХХК
Аудитор Д.Гэрэлчулуун

Үндэсний аудитын газар
Засгийн газрын IY байр
Бага тойруу 6
Улаанбаатар-46
Монгол улс

Хавсралт 1: Агуулга

Хавсралт 2: Аудитын гэрчилгээ

Хавсралт 3: Менежментийн захидал

Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Хавсралт 5: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
7. Шилэн дансны мэдээлэл
8. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
9. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
10. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
11. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
12. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
13. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
14. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
15. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
16. Зөвлөмж
17. Аудитын гэрчилгээний талаарх дүгнэлт

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1-д заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд ИНЕГ-ын харъяа Газрын тусгай үйлчилгээний албаны 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийлээ. САГ-2017/5/СТА-ТШЗСН

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

ИНЕГ-ын харъяа Газрын тусгай үйлчилгээний албаны 2016 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн Сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ИНЕГ-ын харъяа Газрын тусгай үйлчилгээний албаны 2016 оны санхүүгийн тайлангийн аудитыг 2016 оны 10 дүгээр сарын 03-наас 2017 оны 2 дугаар сарын 21-ны хооронд хийхээр төлөвлөн “Ньюбаланс Аудит” ХХК-ийн 1 дугаар багийн аудиторуд хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

ИНЕГ-ын харъяа Газрын тусгай үйлчилгээний алба 2016 оны санхүүгийн тайлангаа 2017 оны 02 дүгээр сарын 10-нд 07/а-223 тоот албан бичгээр ирүүлсэн.

Үндэсний аудитын газар аудитын тайланг 2016 оны 2 дугаар сарын 25-нд ИНЕГ-ын харъяа Газрын тусгай үйлчилгээний албаны удирдлагад гардуулав.

Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

ИНЕГ-ын харъяа Газрын тусгай үйлчилгээний албаны төсөв захирагч нь Монгол улсын Төсвийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Авто тээврийн тухай, Иргэний нисэхийн тухай, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулиудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна. Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль, тогтоомж, түүнд нийцүүлэн гарсан журам, зааварт өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

ИНЕГ-ын харъяа Газрын тусгай үйлчилгээний алба нь Иргэний нисэхийн зохицуулалт, стандартыг сайжруулах, аюулгүй ажиллагааны стандартын хэрэгжилтийг бататгах, аюулгүй ажиллагааны уламжлалыг өөрчлөх, үндэсний эдийн засагт хувь нэмрээ оруулах нь Эрхэм зорилго мөн. Эрхэм зорилгынхоо хүрээнд үйл ажиллагааны стратегийн дор дурьдсан зорилтыг хэрэгжүүлнэ.

- Иргэний нисэхийн салбарт нисэхийн болон нислэгийн аюулгүй ажиллагааг хангасан үйл ажиллагаа явуулах;
- Иргэний нисэхийн үйлчилгээ эрхлэгч байгууллагуудын үйл ажиллагаанд тавих мэргэжлийн хяналтыг сайжруулах;
- Иргэний нисэхийн салбарын хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох;
- Эрх зүйн орчныг бүрдүүлэх замаар өмчийн олон хэлбэрийн өрсөлдөх орчинг бий болгох, иргэний нисэхийн салбарт хувийн хэвшлийг дэмжих;
- Иргэний нисэхийн салбарын хөгжлийг хангах зорилгоор үр ашигтай, олон улсын жишигт нийцсэн хөрөнгө оруулалтын бодлогыг хэрэгжүүлэх, дэвшилтэт шинэ техник технологийг нэвтрүүлэх;
- Иргэний нисэхийн салбарт сахилга, дэг журмыг тогтоох, хэрэгжүүлэх;
- Нарийн мэргэшсэн, өндөр боловсрол бүхий салбарын мэргэжлийн боловсон хүчний мэдлэг, чадварыг олон улсын иргэний нисэхийн байгууллагын стандарт, шаардлагын түвшинд хүргэх;
- Гадаад хамтын ажиллагааг үр ашигтай өргөжүүлэн хөгжүүлэх;

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д “Төсвийн байгууллага нь түүний үйл ажиллагааг үр ашигтай удирдлагаар хангаж, ажлын үр дүнг хариуцах үүрэг бүхий төсвийн шууд захирагчтай байна” гэж заасан байна.

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4.18-д “төсвийн бусад байгууллагын дарга (захирал, эрхлэгч) тухайн байгууллагын төсвийн шууд захирагч байна” гэж заасны дагуу тус байгууллагын дарга Төсвийн захирагчийн үүргийг гүйцэтгэж байна. ИНЕГ-ын харъяа Газрын тусгай үйлчилгээний албаны 2016 оны төсвийг Сангийн яамны төрийн сангаас олгож байна.

Төсвийн шууд захирагчтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд байгууллагатай холбоотой хуулиудыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

ИНЕГ-ын харъяа Газрын тусгай үйлчилгээний албаны үйл ажиллагааны талаар ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын аргазүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар ИНЕГ-ын харъяа Газрын тусгай үйлчилгээний албаны 2016 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс төсвийн захирагчийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансдад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горим, сорил 28-г гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад ИНЕГ-ын харъяа Газрын тусгай үйлчилгээний албаны нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг 2013 онд боловсруулан мөрдөж байна. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журамтай нийцэж байна.

ИНЕГ-ын харъяа Газрын тусгай үйлчилгээний албаны санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

ИНЕГ-ын харъяа Газрын тусгай үйлчилгээний алба ИНЕГ-ын хэмжээнд “MACS” санхүүгийн програмыг ашиглаж 2016 оны санхүүгийн тайлангаа тайлагнаж байна.

Материаллаг байдлыг тооцсон тухайд:

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2016 оны 3-р улиралын нийт зардлын 1 хувиар тогтоож, хүлээн зөвшөөрөх алдааны түвшинг 56.5 сая төгрөг гэж тооцсон. Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлыг 2016 оны жилийн эцсийн нийт зардлын дүнгээр түвшинг шинэчлэн тогтоож 78.9 сая төгрөг болгож тооцсон. Учир нь нийт орлого, нийт хөрөнгө, цэвэр хөрөнгийн дүнгүүд өндөр байгаа тул нийт зардлаас тооцох нь зүйтэй гэж үзсэн.

Дотоод хяналт:

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. ИНЕГ-ын харъяа Газрын тусгай үйлчилгээний албаны дотоод хяналт эрсдлийг төлөвлөлтийн үед бага гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт санхүү, бүртгэл, төсвийн чиглэлээр хангалттай хяналт хийж чаддаггүй байна.

Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

2016 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

ИНЕГ-ын харъяа Газрын тусгай үйлчилгээний албаны захирагч нь 2016 онд улсын төсвөөс 4,847.0 сая төгрөгийн санхүүжилт, үндсэн үйл ажиллагааны орлогоор 2,325.1 сая төгрөг, нийт 7,172.1 сая төгрөгийн эх үүсвэртэй ажилласан байна. 2016 онд 2,036.9 сая төгрөгийн орлого олох төсөв батлагдснаас 2,325.1 сая төгрөгийн орлого олж, батлагдсан төсвийг 288.2 сая төгрөгөөр давуулан биелүүлж ажилласан байна. Үүнээс урсгал зардалд 7,495.2 сая төгрөг батлагдсанаас 7,896.1 сая төгрөгийг зарцуулж, батлагдсан төсвийг 400.9 сая төгрөгөөр хэтрүүлсэний гол зардлууд нь цалин хөлс, НДШ, ажилчдын хоолны зардлууд 506.8 сая төгрөгөөр хэтэрсэн нь Ази Европын Дээд хэмжээний АСЕМ-ийн уулзалтын ажлын хүрээнд илүү цаг ажилласан цалин, 7 сард ИНЕГ-ын тушаалаар АСЕМ-ын үйл ажиллагааг сайн зохион байгуулсан хүн бүрт олгосон 400.0 мянган төгрөгийн урамшуулал нөлөөлсөн.

Шилэн дансны мэдээлэл

ИНЕГ-ын харъяа Газрын тусгай үйлчилгээний алба нь Шилэн дансны тухай хуулийн дагуу төсвийн өмч хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн захирагчийн шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байхад нийцүүлэн shilendans.gov.mn сайтад батлагдсан маягт хавсралтуудын дагуу төсөв, гүйцэтгэлийн 5.0 сая төгрөгөөс дээш худалдан авах ажиллагаа, бусад зарлагын гүйлгээний мэдээллийг сар бүр шилэн дансанд байршуулж байна.

Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 37 эрсдлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 24 хяналтын болон нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Гол, онцлог гүйлгээний талаарх тайлбар:

ИНЕГ-ын харъяа Газрын тусгай үйлчилгээний албаны 2016 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний мөнгөн хөрөнгө, бараа материал, хөрөнгө, бусад орлого, тээвэр шатахуун зэрэг дансанд ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

Эдгээр шалгасан нарийвчилсан сорил нь тус байгууллагын нийт орлогын 75.9 хувь, мөнгөн хөрөнгийн 20.6 хувь, нийт зардлын 5.6 хувь нийт хөрөнгийн 44,3 хувийг тус тус эзлэж байна.

Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг доор тэмдэглэв. Үүнд:

1. Шүүхийн шийдвэрийн дагуу 2 ажилтанд ажлаас халагдсаны нөхөн төлбөрт 18.5 сая төгрөгийг Цалингийн зардлаас олгосон нь Захиргааны ерөнхий хуулийн 103.1-т заасны дагуу "Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Менежментийн захидлаар цаашид Захиргааны ерөнхий хуулийн холбогдох заалтуудыг хэрэгжүүлж ажиллах талаар удирдлагад зөвлөмж хүргүүлэв.

2. Авлага, өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн акт болон тулган баталгаажуулах захидлын дүнтэй тулгахад 156.0 сая төгрөгийн авлага, 1.5 сая төгрөгийн өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.6.-т "Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Менежментийн захидлаар авлага, өглөгийн үлдэгдлийг харилцагчтай тооцоо нийлж баталгаажуулах, барагдуулах арга хэмжээ авч ажиллах талаар удирдлагад зөвлөмж хүргүүлэв.

3. Завсрын тайланд хийсэн аудитаар ИНЕГ-ын харьяа ГТҮА нь 49.4 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, бага үнэтэй түргэн элэгдэх зүйлсийг худалдан авч зардлаар тайлагнасан байгаа нь Сангийн Сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Төсөвт багууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ыг мөрдөөгүй, НБББББ-ийн 4.3-ын бараа материалын бүртгэлийн 3-т заасан "Нэг жилээс их, гурван жилээс бага ашиглалтын хугацаатай хөрөнгийг хангамжийн материалаар бүртгэж карт хөтлөнө" гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Завсрын аудитаар холбогдох ажилтнуудад дээрх алдааг танилцуулж, жилийн эцсийн аудитаар данс бүртгэлд тусгуулан, санхүүгийн тайланг гаргуулав.

4. Бараа материалын тайлангийн үлдэгдлийг нягтлан бодох бүртгэлээр гарсан гүйлгээ балансын үлдэгдэлтэй тулган шалгахад түлш шатахууны үлдэгдэл 3.2 сая төгрөгөөр зөрүүтэй байгаа нь санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Асуудлыг холбогдох ажилтнуудад танилцуулж шатахууны эцсийн үлдэгдлийг бараа материалын тайланд илүү тусгасныг жилийн эцсийн санхүүгийн тайланд үнэн зөв тусган залруулга хийлгэв.

5. Газрын үйлчилгээний жолооч нарын шатахуун зарцуулалтын тооцоо бодохдоо тоо бүртгэгчийн гаргасан түлш шатахууны үлдэгдлээр гаргаж байгаа нь жолоочоос авах авлагын үлдэгдлээс зөрүүтэй, мөн шатахуун тээврийн жолооч нарын тооцоог бодохдоо шатахууны картын хуулгын үлдэгдлээр гүйцэтгэлийг гаргаж, зарцуулалтыг тогтоосон нормоор тооцохгүй байгаа нь Сангийн Сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Төсөвт багууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ыг мөрдөөгүй, НБББББ-ийн 4.9.8-д "Зардлыг оновчтой ангилж хуримтлуулан бүртгэх, бүтээгдэхүүн үйлчилгээний өртгийг үнэн зөв, бодитой тооцоолохын тулд дотоод хяналттай холбоотой горимуудыг хэрэгжүүлнэ" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Хэдийгээр үйлчлүүлэгч байгууллага аудитаар илэрсэн зөрчлийг арилгах талаар ажиллаж байгаа хариу ирүүлсэн боловч эцэслэж үр дүнд хүрээгүй тул Менежментийн захидлаар жолоочийн тооцоо, шатахууны үлдэгдлийг үнэн зөв гаргаж санхүүгийн тайланд толилуулж байх талаар удирдлагад зөвлөмж хүргүүлэв.

Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:

Аудитаар нийт 52,6 сая төгрөгийн алдааг илэрснийг залруулсан тул залруулагдаагүй алдаа байхгүй болно.

Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

ИНЕГ-ын харъяа Газрын тусгай үйлчилгээний алба 2016 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад гүйцээж мөшгин шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал байхгүй.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

ИНЕГ-ын харъяа Газрын тусгай үйлчилгээний алба 2016 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 282.3 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 52.6 сая төгрөгийн алдааг залруулж, 229.7 сая төгрөгийн зөрчилд менежментийн захидлаар удирдлагад зөвлөмж хүргүүлэв.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

ИНЕГ-ын харъяа Газрын тусгай үйлчилгээний албанд өмнөх оны аудитаар акт албан шаардлага өгөгдөөгүй бөгөөд санхүүгийн үйл ажиллагаанд 2 зөвлөмж өгснийг 50 хувьтай биелүүлж ажиллаж байна. Үүнд:

- Нийт дүнгийн 100'242.6 мянган төгрөгийн авлагыг харилцагч байгууллага болох МИАТ ХК, Нүхт Тур ХХК нарын 64'620.0 мянган төгрөгийн тооцоо нь 2011 оны ИНЕГ-ын дотоод хяналтаар тарифийн зөрүүгээс тавигдсан учраас тус байгууллагууд нь хүлээн зөвшөөрдөггүй бөгөөд тухайн үеийн ИНЕГ-ын Санхүү хариуцсан дарга нарт танилцуулсан боловч шийдвэр гаргаагүй байна. Мөн одоогийн СЭЗХ-ийн дарга нь 2016 оны 12 сард томилогдсон. ЗТАЖЯамны тооцоо болох 38'934.6 мянган төгрөг нь мөн ИНЕГ-т ирсэн шалгалтаар тавигдсан дүн болохоор одоогоор мөн шийдвэрлэх түвшинд шийдвэрлэгдээгүй байна.

- Агро Баян ХХК 310.0 мянган төгрөг, Дорнын Үлэмж ХХК –ний 310.0 мянган төгрөг, Монконкорд ХЗХ-ны 200.0 мянган төгрөгийн өглөгийг тооцоо нийлж тооцоог барагдүүлсан болно.

Зөрчилгүй санал дүгнэлт

ИНЕГ-ын харъяа Газрын тусгай үйлчилгээний алба 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв илэрхийлэгдсэн байна.

Аудитлагдсан санхүүгийн тайлан ... хуудас, менежментийн захидал ... хуудсыг тус тус хавсаргав.

Аудитын тайланг

Хянасан:

Санхүүгийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор

С.Энхзаяа

Аудитын менежер

Я.Самбууням

Бэлтгэсэн:

“Ньюбаланс аудит” ХХК-ний аудитор:

Д.Гэрэлчулуун

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

2016.01.01 - 2016.12.31

ИНЕГазрын харьяа ГТҮАлба

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	197,680,913.96	125,972,565.92
1.1.2	Дансны авлага	1,596,597,571.26	766,014,764.78
1.1.3	Ажилчдаас авах авлага	1,568,617.50	
1.1.4	Бусад авлага	74,710,603.23	146,300,370.82
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө		
1.1.6	Бараа материал	817,449,037.87	734,151,707.86
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо		
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө		
1.1.9	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)		
1.1.10			
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	2,688,006,743.82	1,772,439,409.38
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө		4,056,195,207.45
1.2.2	Биет бус хөрөнгө		
1.2.3	Биологийн хөрөнгө		
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт		
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө		
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө		
1.2.7	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө		
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө		
1.2.9			
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	-	4,056,195,207.45
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	2,688,006,743.82	5,828,634,616.83
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг		
2.1.1.2	Цалингийн өглөг		
2.1.1.3	ХАОАТ өр	1,595,511.00	9,271,558.15
2.1.1.4	ЭМД-ийн өглөг	15,195,725.05	
2.1.1.5	Бусад өглөг	115,040,337.25	40,021,564.64
2.1.1.6	Хүүний өглөг		
2.1.1.7	Системийн өглөг	2,868,869,019.35	2,445,980,676.55
2.1.1.8	Урьдчилж орсон орлого		
2.1.1.9	Нөөц /өр төлбөр/		
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр		
2.1.1.12			
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	3,000,700,592.65	2,495,273,799.34
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр		
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл		
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн		
2.2	Өр төлбөрийн нийт дүн	3,000,700,592.65	2,495,273,799.34

2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч:- төрийн		
2.3.2	- хувийн		
2.3.3	Халаасны хувьцаа		
2.3.8	Хуримтлагдсан ашиг (алдагдал)	(312,693,848.83)	3,333,360,817.49
2.3.8.1	Тайлангийн үеийн		3,333,360,817.49
2.3.8.2	Өмнөх үеийн	(312,693,848.83)	
2.3.11	Эздийн өмчийн дүн	(312,693,848.83)	3,333,360,817.49
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	2,688,006,743.82	5,828,634,616.83

Баталгаажуулсан: Аудитор:

/Д.Гэрэлчулуун/

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

2016 оны 12 сарын 31

ИНЕГазрын харьяа ГТҮАлба

/төгрөгөөр/

БАЛАНСЫН ЗҮЙЛ	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО	-	7,172,084,230.12
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	-	4,847,022,397.00
Засгийн газрын бусад түвшнээс авах тусламж санхүүжилт		
Улсын төвлөрсөн төсвөөс	-	4,847,022,397.00
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		4,847,022,397.00
Төсөвт байгууллагаас		
Нийгмийн даатгалын сангаас		
Газрын үйлчилгээний орлого		1,816,925,168.33
Шатахуун тээврийн орлого		419,646,123.70
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого		
төсвийн жилийн явцад ОУБ-аас өгсөн санхүүжилт		
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд		
Дээд шатны төсвийн захирагчаас өгсөн санхүүжилт		
Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан		
Хүүгийн орлого		1,234,810.06
Бусад орлого		88,490,541.09
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	-	7,173,319,040.18
АЖИЛЛАГСАДТАЙ ХОЛБОГДСОН ЗАРДАЛ	-	5,344,106,504.79
Үндсэн болон нэмэгдэл цалин		4,813,991,742.00
Нийгмийн хамгааллын шимтгэл		530,114,762.79
Бараа үйлчилгээний урсгал зардал	-	2,552,046,925.35
Тогтмол зардал	-	124,978,429.12
Гэрэл цахилгаан		34,453,748.79
Түлш, халаалт		54,301,686.08
Цэвэрлэгээний зардал		24,883,611.25
Цэвэр, бохир ус		11,339,383.00
Үйл ажиллагааны зардал	-	606,607,331.35
Хоол		298,225,269.00
Сэлбэг хэрэгсэл, засварын зардал		308,382,062.35
Бусад бараа үйлчилгээний зардал	-	1,772,287,411.88
Бичиг хэргийн зардал		26,531,638.32
Тээвэр, шатахуун		1,271,898,023.54
Шуудан, харилцаа холбоо		8,651,175.52
Дотоод албан томилолт		99,757,600.00
Банкны үйлчилгээ		185,700.00
Албан конторын зардал		13,169,223.00
Бага үнэтэй түргэн элэгдэх зүйл		68,469,193.86
Нормын болон дүрэмт хувцас ,зөөлөн эдлэл		71,470,997.28
Төлбөр хураамж жижиг татварууд		
Урсгал засвар		
Үндсэн хөрөнгийн элэгдэл		2,646,394.94
Бараа үйлчилгээний бусад зардал		332,000.00
Бараа материал акталсаны зардал		
Мэргэжлийн зөвлөх үйлчилгээний зардал		3,720,000.00
Хөрөнгийн даатгал		100,265,436.92
Газрын төлбөр		73,017,504.20
Гал команд		1,852,756.90
Үл хөдлөх хөрөнгийн татвар		20,729,767.40
Хичээл үйлдвэрлэлийн дадлага,сургуулилалтын зардал		9,590,000.00

ЗАСГИЙН ГАЗРЫН БАЙГУУЛЛАГА,НЭГЖҮҮДЭД		
Төсвийн ерөнхийлөн захирагчидад олгосон санхүүжилт		
Төвлөрүүлэх шилжүүлэг		
НИЙГМИЙН ХАМГААЛАЛЫН ЗАРДАЛ	-	48,173,753.00
Ажил олгогчоос өгөх бусад тэтгэмж		12,910,000.00
Түлээний хөнгөлөлт		17,800,000.00
Баяр ёслол арга хэмжээ		16,379,760.00
Бусад		1,083,993.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	-	7,896,153,430.14
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	-	(722,834,389.96)
Бусад зардал ба алдагдал		
Хөрөнгө шилжүүлсэний олз		4,056,195,207.45
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	-	3,333,360,817.49

Баталгаажуулсан: Аудитор:

/Д.Гэрэлчулуун/

АУДИТ ХИЙГДСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

2016 оны 12 сарын 31

ИНЕГазрын харьяа ГТҮАлба

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмч	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	НИЙТ ДҮН
1	2014 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл				-
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				-
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл				-
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				-
5	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				-
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				-
7	Тайлант үеийн үр дүн			(312,693,848.83)	(312,693,848.83)
8	2015оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	(312,693,848.83)	(312,693,848.83)
9	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			312,693,848.83	312,693,848.83
10	Дахин илэрхийлсэн үлдэгдэл				-
11	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				-
12	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				-
13	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				-
14	Тайлант үеийн үр дүн			3,333,360,817.49	3,333,360,817.49
15	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	3,333,360,817.49	3,333,360,817.49

-

Баталгаажуулсан: Аудитор:

/Д.Гэрэлчулуун/

АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2016.01.01 - 2016.12.31

#

(төгрөгөөр)

БАЛАНСЫН ЗҮЙЛ	Өмнөх он	Эцсийн үлдэгдэл
ҮНДСЭН АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Мөнгөн орлогын дүн (+)	6,844,403,758.03	7,793,193,617.37
Бараа борлуулсан,үйлчилгээ үзүүлсний орлого	2,151,584,616.69	2,695,515,702.37
Эрхийн шимтгэл,хураамж,төлбөрийн орлого	-	-
Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	22,171,279.00	31,262,106.00
Татаас санхүүжилтийн орлого	4,504,960,189.30	4,847,022,397.00
Бусад мөнгөн орлого	165,687,673.04	219,393,412.00
Мөнгөн зарлагын дүн (-)	6,724,738,621.85	7,866,136,775.47
Ажиллагчдад төлсөн	3,586,567,470.00	4,189,855,949.36
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	904,499,306.00	1,062,300,000.00
Бараа материал худалдан авахад төлсөн	174,153,114.00	263,211,262.00
Ашиглалтын зардалд төлсөн	67,006,641.01	78,922,829.62
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	1,180,051,752.83	1,327,367,592.28
Татварын байгууллагад төлсөн	370,325,000.00	442,500,000.00
Даатгалын төлбөрт төлсөн	57,332,368.00	39,536,443.00
Бусад мөнгөн зарлага	384,802,970.01	462,442,699.21
ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН	119,665,136.18	(72,943,158.10)
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН		
Мөнгөн орлогын дүн (+)	583,848.52	1,234,810.06
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
Биет бус хөрөнгө борлуулсны орлого		
Хүлээн авсан хүүний орлого	583,848.52	1,234,810.06
Хүлээн авсан ногдол ашиг		
Улсын төсвийн хөрөнгө оруулалт		
Мөнгөн зарлагын дүн (-)	-	-
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн өөрийн хөрөнгө		
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР	583,848.52	1,234,810.06
САНХҮҮГИЙН АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Үйл ажиллагааны үндсэн үзүүлэлттэй шууд холбоотой зардал		
Мөнгөн орлогын дүн (+)		
Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
Төрөл бүрийн хандив		
Мөнгөн зарлагын дүн (-)		
Зээл авсан, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн		
Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		
Төлсөн ногдол ашиг		
АНХҮҮГИЙН АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ Д	-	-
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	120,248,984.70	(71,708,348.04)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	77,431,929.26	197,680,913.96
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	197,680,913.96	125,972,565.92

Баталгаажуулсан: Аудитор:

/Д.Гэрэлчулуун/

ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

2016.01.01 - 2016.12.31

###

/мянган төгрөгөөр/

д/д	Эдийн засгийн ангилал	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	
				/+илүү, -дутуу/	Хувь
А. ОРЛОГО					
1	Санхүүжилтийн орлого	-	4,847,022.4	4,847,022.4	
2	Газрын үйлчилгээний орлого	1,733,370.5	1,816,925.2	83,554.7	104.8%
3	Нийтийн үйлчилгээний орлого	40,000.0	76,566.6	36,566.6	191.4%
4	Шатахуун тээврийн орлого	253,575.0	419,646.1	166,071.1	165.5%
5	Бусад орлого	10,000.0	11,923.9	1,923.9	119.2%
	Үйл ажиллагааны орлогын дүн	2,036,945.5	7,172,084.2	5,135,138.7	352.1%
1	Хөрөнгө шилжүүлсэний олз		4,056,195.2	4,056,195.2	
2	Хүүний орлого		1,234.8	1,234.8	
	ОРЛОГЫН ДҮН	2,036,945.5	11,229,514.2	9,192,568.7	551.3%
1	Үндсэн болон нэмэгдэл цалин	4,331,501.6	4,804,335.4	472,833.8	110.9%
2	Хоол унааны хөнгөлөлт	294,730.5	298,225.3	3,494.8	101.2%
3	НДШ	509,221.9	539,771.1	30,549.2	106.0%
5	Бичиг хэргийн зардал	25,000.0	26,531.5	1,531.5	106.1%
6	Банкны шимтгэл	500.0	185.7	(314.3)	37.1%
7	Гэрэл цахилгааны зардал	32,000.0	34,453.7	2,453.7	107.7%
8	Түлш, халаалтын зардал	53,000.0	53,000.0	-	100.0%
9	Цэвэр, бохир усны зардал	18,000.0	12,290.1	(5,709.9)	68.3%
10	Тээвэр, шатахууны зардал	1,310,000.0	1,271,898.0	(38,102.0)	97.1%
11	Шуудан холбооны зардал	15,000.0	8,651.2	(6,348.8)	57.7%
12	Дотоод томилолтын зардал	100,000.0	99,757.6	(242.4)	99.8%
13	Авто сэлбэг, хэрэгсэл	370,500.0	326,250.8	(44,249.2)	88.1%
14	Барилгын урсгал засвар	40,000.0	43,538.2	3,538.2	108.8%
15	Тоног төхөөрөмжийн засвар	10,000.0	6,396.0	(3,604.0)	64.0%
16	Хөдөлмөр хамгаалал	46,329.0	71,470.9	25,141.9	154.3%
17	Аж ахуйн зардал	15,000.0	13,835.9	(1,164.1)	92.2%
18	Сургалтын зардал	7,244.0	9,590.0	2,346.0	132.4%
19	Гал унтраах зардал	3,000.0	1,852.7	(1,147.3)	61.8%
20	Цэвэрлэгээ хог хаягдлын зардал	32,000.0	24,883.6	(7,116.4)	77.8%
21	ҮХЭ зардал		2,646.4	2,646.4	
24	Газрын татвар	19,691.4	73,017.5	53,326.1	370.8%
25	ҮХХ-ийн татвар	10,394.9	7,363.8	(3,031.1)	70.8%
26	Тээврийн хэрэгслэлийн татвар	13,653.8	13,365.9	(287.9)	97.9%
27	Тээврийн хэрэгсэл даатгал		100,265.4	100,265.4	
28	Төлбөр хураамж	17,986.0	4,403.0	(13,583.0)	24.5%
29	Үйлд.бусад зардал			-	
	ДҮН /А/	7,274,753.10	7,847,979.70		
Б. Үйл ажиллагааны бус зардал					
1	Буцалтгүй тэтгэмж	37,900.0	12,910.0	(24,990.0)	34.1%
2	Тэтгэвэрт гаргахад олгох тэтгэмж	182,581.5		(182,581.5)	
3	Түлээний хөнгөлөлт		17,800.0	17,800.0	
4	Баяр ёслол арга хэмжээ, урамшуулал		17,463.7	17,463.7	
5	Бусад			-	
	ДҮН /Б/	220,481.50	48,173.70	(172,307.80)	21.8%
	ЗАРДЛЫН ДҮН	7,495,234.6	7,896,153.4	(172,307.8)	105.3%
В. Ажиллагсад бүгд		286	286	-	
1	Ажилтан	286	286	-	

Баталгаажуулсан: Аудитор:

/Д.Гэрэлчулуун/

-

7,896,153.40

419,723.90

7,476,429.50

7,172,084.20	-	11,923.90
--------------	---	-----------

4,779,278.30	25,057.10
	298,225.30
525,904.40	13,866.70
	26,531.50
	185.70
	34,453.70
	53,000.00
	12,290.10
	1,271,898.00
	8,651.20
	99,757.60
	326,250.80
	43,538.20
	6,396.00
	71,470.90